

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Гэрэлтүүлгийн угсралтын ажлыг норм ба дүрэм /БНбаД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

### Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:

- ❖ Угсралтын ажил гүйцэтгэх үе шатны график
- ❖ Зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийх фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг заавал хийлгэнэ.

Угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. Норм ба дүрмийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Баруун-Урт сумын төв авто замын гэрэлтүүлгийг Улаабаатар хотын чиглэлд 5 Эрдэнэ төвийн урд хэсгээс эхлэхээр хийж гүйцэтгэнэ.

ДБЭХС ТӨХК-ийн Сүхбаатар аймаг дах салбарын гаргасан техникийн нөхцлийн дагуу талбайн баруун хэсэг, сумын ЗДТГ-ын урд талын хэсгийн гэрэлтүүлгийн цахилгаан хамгамжийн тэжээлийг "Уртын гэгээ" ОНӨҮГ-ын эзэмшлийн гэрэлтүүлгийн самбараас гаргалгаа гаргаж АВВБ4х35 мм.кв хөндлөн огтлолтой хөнгөн цагаан кабель шугам татаж гадна гэрэлтүүлгийн самбар ГГС-4.1-г тэжээнэ.

Гэрэлтүүлгийн самбар нь засвар үйлчилгээ хийх боломжтой иж бүрэн автомат таслууртай, хугацааны реле удирдлагын аппараттай, 3 фазын электрон тоолуур болон 5 гаргалгаатай иж бүрэн самбар хийнэ.

Авто замын гэрэлтүүлэг нь хоёр талаараа байрлах ба замын зорчих хэсэг болон явган замыг бүхэлд нь гэрэлтүүлнэ. LED-120Вт чадалтай гэрэлтүүлэгчийг хийнэ. Гэрэлтүүлгийн шонгийн өндөр 9м, ГГС-4.1 самбараас АВВБ(4х25)мм.кв хөндлөн огтлолтой хөнгөн цагаан кабель шугамаар гэрэлтүүлгийн 4-н групп тэжээнэ. Гадна гэрэлтүүлгийн шугамын фаз хоорондын ачааллыг тэнцүүлж А,В,С гэсэн 3 фазад ачааллыг тэнцүүлнэ.

Газардуулга нь гэрэлтүүлгийн самбарын газардуулгын хэвтээ хүрээг 40х4мм-ийн туузан гангаар хийнэ. Гэрэлтүүлгийн шонг 200 м тутамд давтан газардуулгийг хийж өгнө. БД30-102-11-ийн 3.17-д заасны дагуу газардуулж өгнө. Газардуулгын хэвтээ бүрээг газрын тэгшилэгдсэн түвшингээс доош 0.5 м-ийн гүнд шуудуунд суулгана.

Угсралтын ажлыг эхлэх үед, үе шат бүрт захиалагч, хангагч байгууллагад мэдэгдэж зөвшилцөж байх ба кабелийн сувгийг газрын тэгшлэгдсэн түвшингээс -0.7м гүнд тавих ба зам талбай болон инженерийн шугам сүлжээтэй огтлолцох цэгт ган хоолойд сүвлэнэ.

Угсралтын ажлыг зураг төслийн дагуу болон Цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101-03, Цахилгаан техникийн ажил БНБД-3.05.0.6-90-ын дагуу гүйцэтгэнэ. Бүх газар шорооны ажил, угсралтын ажлын үед цахилгаан шугам сүлжээ болон ажлын зурагт зөвшилцсөн бүх байгууллагуудаас мэргэжлийн хүмүүс байлцуулах хэрэгтэй ба техникийн шийдлийг өөрчлөх тохиолдолд захиалгч, зураг зохиогчийн зөвшөөрлийн дагуу өөрчлөлт хийнэ.



Гэрэлтүүлгийн шонгууд дээр туг, сурталчилгааны самбарын суурь болон орон нутгийн онцлог (морь, хун шувуу гэх мэт)-ийг харуулсан хэлбэр дүрс бүхий жижиг элементийг хийж өгнө. Ажил эхлэхээс өмнө захиалагч, зохиогч нартай зөвшилцөж хийж гүйцэтгэнэ. (үүнийг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад онцгой анхаарна.)

Угсралтын ажлыг зурагт заасан технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

**Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:**

Монгол улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна”, 14.6-т “энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор харуу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.

Дээрхи техникийн тодорхойлтонд заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөл, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Х.ЭНХЦЭЦЭГ

